ИНФЛЯЦИЙН ТАЛААРХ ЗАРИМ АЖИГЛАЛТ

Б.Эрдэнэбат

Манчестрийн Их Сургууль

“Инфляци хаана ч, хэзээ ч үргэлж мөнгөтэй холбоотой “

Милтон Фридман (1968)

“Манай мөнгө яагаад үнэ цэнээ алдаад байна вэ? Инфляци өндөр байгаа нь бид инфляцийн хүлээлттэй байгаагаас, харин инфляцийн хүлээлттэй байгаа нь бид өндөр инфляцитай байгаагаас болоод байгаа юм биш үү”

Роберт Солоу (1979)


Өнөөдөр бидний амьдралд өндөр инфляци ямар хор хөнөөлтэй болохыг хүн болгон ухаарч үүний эсрэг бололцоотой бүхнээ хийх зайлшгүй шаардлагатай болжээ. Ардчилсан нийгэмд амьдарч байгаагийнхаа хувьд та бид бүхэн Монголд юу болж байгаатай шууд холбоотой бөгөөд нийгэм эдийн засаг маань ямархуу байдалтай байгаа нь бид бүхний оролцоо хэр ухаалаг, идэвхитэй байгаагийн нэг илрэл билээ. Энэхүү бодлынхоо үүднээс өндөр инфляци яаж үүсдэг, үүнийг хянахад та бид юу хийж болох талаар өөрийн бодлоо хуваалцах гэсэн юм.

Инфляцийн хор хөнөөл газар сайгүй бий. Хэрвээ та хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх гэж хэдэн төгрөгөө хадгалж байгаа бол, хэрвээ та бизнесээ өргөжүүлэх гэж хөрөнгө оруулалт хайж байгаа бол, хэрэвээ та тэтгэвэртээ гарсныхаа дараа хэрэглэнэ дээ гэж цалингаасаа багахан ч гэсэн хурааж байгаа бол инфляци үүнээс маань сайнаар бодоход хумсална муугаар бодвол үгүй хийдэг. Жишээ нь инфляци жилийн 15.1% байвал 5 хүрэхгүй жилийн дотор юмны үнэ 2 дахин үнэтэй болно. Америкийн ерөнхийлөгч Роналд Рейган нэгэнтээ инфляцийг “дээрэмчин мэт хэрцгий, алуурчин мэт аюултай” хэмээн тун онож тодорхойлсон байдаг.

Инфляци яаж үүсээд байна вэ? Эхлээд үүнийг тодорхойльё: *Инфляци гэдэг бол нийт үнийн түвшингийн тасралтгүй өсөлт*. Үүнийг тайлбарлахын тулд үнийн түвшин, үнийн түвшинг тайлбарлахын тулд мөнгө гэж юу болохыг эхлээд тайлбарлах хэрэгтэй. Эдийн засагт хүний хэрэгцээг хангадаг зүйлс бүхэн өөрийн гэсэн үнэ цэнэтэй. Үнэ цэнэ гэдгийг одоохондоо Төгрөг, Доллар гэх мэт мөнгөн тэмдэггтэй холболгүй зүгээр л нэлээн хийсвэрлэж бодьё. Жишээ нь, мах өөрийн гэсэн үнэ цэнэтэй, учир нь бидний олонхи маань махан тэжээлтэн, хөдөлмөр өөрийн гэсэн үнэ цэнэтэй, учирийг нь ажил хийж үзсэн хүн болгон мэднэ, хөрөнгө өөрийн гэсэн үнэ цэнэтэй, учир нь та үүнийг ихэнх тохиолдолд зовж байж цуглуулдаг. Тэгвэл мөнгө ч гэсэн өөрийн гэсэн үнэ цэнэтэй, учир нь бид үүнийг мах, хөдөлмөр зэрэг үнэт зүйлсийг хооронд нь солилцож хэрэглэхэд ашигладаг. Тэгвэл үнийн түвшин гэдэг маань энэ мөнгө гэдэг үнэт зүйлсийн эрэлт болон нийлүүлэлтийн тэнцвэрээр тогтож байдаг бөгөөд үүгээрээ ч бусад бүхий л үнэт зүйлс, жишээ нь мах, хөдөлмөр болон хөрөнгийн үнэ хэрхэн тогтдоггоос чанарын ялгаагүй.

Доорх хялбаршуулсан зураг дээр үүнийг тайлбарлая.

Зураг 1. Үнийн Түвшин Хэрхэн Тогтдог Вэ?



Мөнгөний эрэлтийг $M^d = P \cdot L(Y,i)$ гэж үзье. P-үнийн түвшин, $L(Y,i)$-мөнгөний бодит эрэлт, Y- бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, ДНБ, i-хүү. Тэгшитгэлээр үнийн түвшин бага үед хүмүүс гар дээрээ их мөнгө байлгахгүй нь. Мөн Y өндөр бол мөнгөний эрэлт илүү хэвтээ болж, i өндөр бол мөнгөний эрэлт илүү босоо хэлбэртэй болдог.

Харин мөнгөний нийлүүлэлт M^s үнийн түвшингөөс хамаарахгүй учир нь Төв Банк хэзээ ч цаасан мөнгө хэвлэн гаргах боломжтой бөгөөд үүнийгээ жишээ нь төрийн албан хаагчдын цалин хөлс эсвэл тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх хэлбэрээр гүйлгээнд нэвтрүүлж болно. Эдийн засаг дахь тэнцвэрийн үнийн түвшин, $P*$, нь M^d, M^s -ийн огтлолцолын цэг дээр тогтоно.

Энэхүү график зөвхөн цаг хугацааны нэгхэн үед, жишээ нь 2006 онд, үнийн түвшин хэрхэн тогтож байгааг харуулж байна. Мэдээж 2007 онд мөнгөний эрэлт ч нийлүүлэлт ч, тэдгээрийн тэнцвэрээс тогтох үнийн түвшин ч ондоо байна. Энэхүү шинэ үнийн түвшинг $P**$ гэж тэмдэглэе. Тэгвэл 2007 оны инфляцийг $\frac{P** - P*}{P*}100\%$ гэж хэмжих бөгөөд хэрэв P-г та бидний хэвлэл мэдээллийн хэрэгслээр олонтаа сонссон Хэрэглээний Барааны Үнийн Индэксээр орлуулбал энэ нь Монголын хувьд 15.1% байж[1].


График маань хэдийгээр маш энгийн ч мөнгөний бодлого хэрхэн хэрэгждэг болохыг үзүүлж байна. Жишээ нь, ирэх жил ДНБ-ний өсөлт энэ жилийнхээс өндөр байна гэж тооцоолвол мөнгөний эрэлтийн муруй илүү хэвтээ болно. Энэ үед мөнгөний нийлүүлэлтийг хэвээр нь хадгалбал график дээр үнийн түвшин маань буурна. Энэхүү үзэгдэлийг дефляци хэмээх бөгөөд харамсалтай нь инфляцитайгаа адил муу нөлөөтэй. Аж үйлдвэржсэн улсуудыг хамарсан 30-аад оны хямрал, саяхан Японд болсон эдийн засгийн зогсонги байдлыг үүнтэй холбон тайлбарладаг. Тэгэхээр үнийн түвшинг тогтоворжуулах нэг арга маань мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл

[1] Хэрэглээний сагсанд маань өнөөдөр 300 гаруй бараа бүтээгдэхүүн багтаж байгаа бөгөөд ерөнхийдөө тэдгээрийн үнийг хэрэглээнд эзлэх жингээр нь жигнэж нийт сагсны үнэ буюу ХБҮИ-ийг тооцоолдог.

M^s шулууныг баруун тийш нь хөдөлгөнө гэсэн үг.[2] Энэхүү өөрчлөлтөөс мөнгөний өсөлтийн хувийг $\frac{M**-M*}{M*}100\%$ хэмээн тооцдог ($M**$болон $M*$ нь жишээ нь 2007 болон 2006 онд эдийн засагт эргэлдэж байсан нийт мөнгөний хэмжээ). Дэлхийн эдийн засгийн тэргүүлэгч улсуудад өнөөдөр инфляцийг жилд 2-3%-д барьж байвал зохистой гэж үзэж байна.

Графикаас мөн мөнгөний нийлүүлэлтийг эрэлтийнх нь өсөлттэй уялдуулахгүй бол инфляци үүсэж байгааг бас харж болно. Энэхүү алдааг өндөр инфляцийн хамгийн гол буруутан нь гэж үздэг бөгөөд Монголд ч үүний шинж тэмдэг нэлээд ажиглагдах боллоо.

Зураг 2. Монголын инфляци болон мөнгөний өсөлтийн хувь (%)[3]



Зураг 2 дээр Монголын инфляци болон мөнгөний өсөлтийн хувь хэрхэн өөрчлөгдөж ирснийг харуулж байна. Гүйлгээнд байгаа мөнгөний нийт хэмжээг хурдацтай ихэсгэх тусам инфляци өндөр, өсөлтийн хувь бага байвал инфляци бага байгаа ерөнхий дүр зураг харагдаж байна. Энэхүү хоёрын өөрчлөлтийн чиглэл нь ерөнхийдөө нэг зүгт, корреляцийн коеффициент нь 0.88%. Сүүлийн 3 жилд мөнгөний нийт хэмжээ асар хурдацтайгаар, жишээ нь 2007 онд 2006 онтой харьцуулбал 77.9% -аар, өсчээ. Тэгвэл энэ маань инфляци улам гаарна гэсэн үг мөн үү? Харамсалтай нь ихэнх онолын загварууд болон дэлхийн улс орнуудын гашуун туршлага “Тийм” хэмээн хариулах ажээ. Зураг 3-т


[2] Дээрх шинжилгээнээс инфляцийг тодорхой түвшинд барихын тулд практик дээр мөнгөний нийлүүлэлтийг яг хэдэн хувиар өөрчлөх мэдээллийг авах боломжгүй. Тэрхүү мэдээллийг тоон мэдээллийг үндэслэн үнэлж гаргадаг бөгөөд уншигч эрхэмээ мэргэжлийн нэр томьёогоор дарахгүйн үүднээс хязгаарлав. Гэхдээ энэхүү үнэлгээний чанар амжилттай мөнгөний бодлогын суурь болж байдагийг дурдах нь зүйтэй болов уу.

[3] Инфляцийг ХБҮИ-ээр харин мөнгөний өсөлтийг М1 гэгддэг гүйлгээнд байгаа бэлэн мөнгө болон арилжааны бандуудад байршиж байгаа харилцах, хугацаагүй хадгаламжийн нийт дүнгээс тооцов. Мэдээллийн эх сурвалж: DataStream.

дэлхийн улсуудын 40 жилийн дундаж инфляци болон дундаж мөнгөний өсөлтийн хувийг харуулж байна.

Зураг 3. Инфляци болон мөнгөний өсөлт (%)

(Монгол, 1993-2007, бусад улсууд 1960-2000)[4]



Зурагаас харахад дэлхийн ихэнх улсад олон жилийн дундаж инфляци нэг их өндөр биш тухайлбал нийт улсуудын 73% нь 12%-аас доош хувийн инфляцитай байж.[5] Хамгийн бага нь Сингапур, Герман, Малайз зэрэг улсуудад жилд дунджаар 3% орчим байж. Хэдийгээр энэхүү нийтлэлийн маань гол сэдэв биш ч, инфляци байгалийн нөөц байлагаар баялаг Африк, Латин Америкийн улсуудад хамгийн өндөр байгаа нь сэтгэл түгшээмээр.[6] Ялангуяа Латин Америкийн улсууд яагаад ийм өндөр инфляцитай байсан манайд өнөөдөр хэрэгжээд байгаа популист макро-эдийн засгийн арга хэмжээнүүдээс үүдэлтэйг харах үнэхээр харамсалтай (Dornbusch and Edwards, 1991). Өндөр инфляцитай улсуудын мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь нь ч өндөр, тухайлбал энэ 2 хувьсагчийн корреляцийн коеффициент нь 0.99% буюу маш өндөр хамааралтай байх зүй тогтол ажиглагдаж байна. Энэхүү графикийг 2 янзаар тайлбарлаж болж байна. Эхнийх нь мөнгөнийн нийлүүлэлтийг нэмсэний үр уршиг нь өндөр инфляци нөгөөх нь өндөр инфляцитай улсууд угаасаа мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өндөртэй байдаг гэж. Гэвч

[4] Олон Улсын Валютын Сангийн гишүүн, 1960-2000 оных нь тоо баримт бүрэн 82 орны мэдээлэлд тулгуурлав. Тоо баримтын эх сурвалж Barro (2008). Монголын тоо баримтийн эх сурвалж DataStream.

[5] Энэ нэлээн өндөр тоо гэж үздэг. Гол буруутан нь “Их Инфляци”-ийн он жилүүд гэгддэг 1970-аад он бөгөөд энэ үед мөнгөний нийлүүлэлтийг нэмэх замаар эдийн засгийн өсөлтийг хурдасгадаг гэсэн буруу бодлого улсуудад зонхилж энэхүү муу бодлоготой давхацсан нефтийн хямрал жилийн инфляцийг 10%-аас дээш болгож байжээ.


[6] Эдийн засгийн тогтворгүй байдал болон байгалийн баялагийн хоорондох эерэг хамааралтайг харуулсан судалгааны салбар байдаг бөгөөд сонирхсон хүмүүс Auty (2001) үзэж болно.

ихэнх эдийн засагчид тэдгээрийн тэргүүн эгнээнд илтгэлээ ишлэлээр нь эхэлсэн Фридман мөнгөний нийлүүлэлт нь анхдагч гэж үздэг.

Монгол улс ч энэхүү зүй тогтлоос гажаагүй байгаа нь харагдаж байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс хойших тоо баримтаар 1993-2007 онд мөнгөний нийлүүлэлт жилд дунджаар 40 орчим хувьтай өсөж инфляци ч тэр хэмжээгээр өсөж иржээ. Зурган дээрх дахь бусад улсууд Монголтой адил системийн өөрчлөлт хийгээгүй учир Монголын шилжилтийн эхэн үеийн тоо баримтыг оруулж харьцуулах нь зохистой бус санагдаж болох юм. Иймд Зураг 4-т зөвхөн Монголын инфляци нэг оронтой тоонд орж ирсэн эхний жил буюу 1998 оноос хойших тоо баримтыг оруулан харьцуулья. Хугацааны дундаж жилийн мөнгөний өсөлтийн хурд 31.28% харин дундаж инфляци 8.2% байна. Хамгийн аюултай дүгнэлт нь хэрэв Монгол улс дэлхийн бусад улсуудаас тэс ондоо л биш юм бол инфляци улаан шугам руугаа тэмүүлж олон жилийн дундаж маань 20% орчим болох нь. Урт хугацааны дундаж инфляци одоогийн 8.2%-аас 20% болно гэдэг маань нь ирэх хэдэн жилийн дотор бид жилийн 20-оос дээш хувийн инфляцитай байна гэсэн үг. Энэ бол үнэхээр харамсалтай ухралт.

Зураг 4. Инфляци, Мөнгөний нийлүүлэлтийн хурд


(Монгол 1998-2007, бусад улсууд 1960-2000)



Нэгэнт инфляци өндөр түвшинд тогтчихвол түүнийг бууруулахад тун түвэгтэй болчихдог. Үүнийг товчхон тайлбарлая. Эдийн засагт ерөнхийдөө хоорондоо байнга харилцаж байдаг 3 зах зээл бий: бараа бүтээгдэхүүний, хөдөлмөрийн, капиталын (хөрөнгийн). Эхний зах зээл дээр үнэ өслөө гэж үзье. Тэгвэл хүмүүсийн бодит цалин, хөрөнгө оруулагчдын бодит өгөөж буурна. Тэгэхээр ажил хаялт ч юм уу, жагсаал цуглаанаар ч юм уу хөдөлмөрийн үнэ буюу цалин хөлс нэмэгдэнэ. Капиталын үнэ ч өсөх хэрэгтэй болно үгүй бол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид хөрөнгө оруулснаас бараа

бүтээгдэхүүнд хөрөнгө оруулсан нь ашигтай болно. Эдгээр зах зээл дээр үнэ өсөх өсөхдөө ирээдүйн инфляцийн хүлээлтийг шингээж өснө. Үнэтэй хөдөлмөр, капитал ашиглахаар үнэтэй бараа бүтээгдэхүүн л үйлдвэрлэгдэнэ, үр дүнд нь нийтлэлийн эхлэлд дурдадгдсан инфляцийн цагираг бий болно. Доорх зурагт энэхүү таамаглал хэр үнэний хувьтайг харуулж байна.

Зураг 5




Зургаас инфляци өндөртэй байсан улсууд ерөнхийдөө өндөртэйгөөрөө л үлдэж байгаа нь харагдаж байна. Зөвхөн Индонези, Чили зэрэг цөөн тооны улсууд л өндөр инфляциа бууруулж бусад өндөр инфляцитай улсуудын инфляци улам гаарсан нь мөн харагдаж байна.

Өндөр инфляци эдийн засагт асар их хор уршигтай гэдгийг эдийн засагчид бүгд хүлээн зөвшөөрдөг бөгөөд үүнийг нь нотолсон эмпирик судалгаанууд ч олон бий (Khan and Senhadji, 2001, Fischer, Sahay, and Vegh, 2002). Зураг 5-д дундаж эдийн засгийн бодит өсөлт (дотоодын нийт бүтээгдэхүүн, ДНБ, -ээр хэмжиж), дундаж инфляцийн хоорондын хамаарлыг 1960-2000 оны тоо ашиглан харуулж байна.


Зургаас урт хугацааны эдийн засгийн өсөлтөөрөө гайхуулагч бүх улсуудад инфляци маш бага байгааг харж болно. Жишээ нь эдгээр улсуудыг жилийн 8.1%-ийн дундаж өсөлтийн хурдаараа тэргүүлэгч Сингапурт 40 жилийн дундаж инфляци нь ердөө 3.2% байх жишээтэй.

Зураг 6. Инфляци болон бодит ДНБ-ий өсөлт (1960-2000)



Мөнгө, санхүүгийн тэлэх бодлого буюу, мөнгөний нийлүүлэлтийг түлхүү хийснээр эдийн засгийн өсөлтөд хүрж болох юм гэсэн алдаатай бодлого дэлхийн зарим улсуудад 70-аад онд байсныг бид мэднэ. Тэгвэл энэ бодлогод манай эрх баригчид найдаад байгаа юм биш байгаадаа гэдэг үүднээс Зураг 7-д дундаж эдийн засгийн бодит өсөлт болон дундаж мөнгөний нийлүүлэлтийн хурдны хоорондын хамаарлыг харуулж байна.

Зураг 7. Мөнгөний нийлүүлэлт болон ДНБ-ий өсөлт (%)



Уг зургаас сайнаар бодоход эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг хэр хурдацтай өсгөх нь эдийн засгийн бодит өсөлтэд нэг их хамаагүй, муугаар бодоход, бас улаан шугам буюу статистикийн үнэлгээ харуулж буйгаар бүр сөрөг хамааралтай гэсэн дүгнэлт гарч байна. Мөн л эдийн засгийн өсөлтөөрөө гайхуулагч бүх улсад мөнгөний нийлүүлтийн хурд жилд дунджаар 10 орчим байж (Монголд 1993 оноос хойш энэ тоо 37.26 байгаа).

Өндөр инфляцитай улс орнууд үүнтэй үндсэндээ 2 аргаар тэмцэж байна.

1. “Инфляцийг онилох” бодлого буюу Төв Банкыг инфляцийн хувь хэмжээг бага түвшинд тогтвортой барьж байх цорын ганц үүрэгтэй болгож үүнийгээ гүйцэтгэхэд ямар л арга хэмжээ авах шаардалагатай байна түүнийгээ хийх бүрэн эрхээр хангах. Өндөрсгөсөн эрхтэй нь уялдуулж хүлээх хариуцлагыг нь ч нэмэгдүүлэх[7].

2. Үндэсний валютаа гадаад валюттай уях эсвэл түүнээсээ бүрмөсөн татгалзаж тогтвортой валютыг өөрийн болгон хэрэглэх. Ингэснээр Засгийн Газрын шахалт дарамтаар болон сайн дураараа Төв Банк мөнгө хэвлэн гаргах боломж нь механикаар хаагдана. Энэхүү стратеги, Европын Холбооны Улсуудад биелэлээ олж Хойд Америкийн улсуудад идэвхитэй хэлэлцэгдэх болсон.

Эдгээр бодлогуудыг зарим улс дангаар нь зарим нь хослуулан хэрэжүүлж байгаа бөгөөд аль ч тохиолдолд зөвхөн нэрийн төдий биш бодлогодоо тууштай байж үүнтэйгээ зэрэгцүүлэн мөнгөний нийлүүлэлтийн хурдаа эрс багасгаж санхүүгийн сахилга батыг төсвийн бүхий л шатанд хэрэгжүүлж, төрийн секторынхээ нийт эдийн засагт эзлэх хэмжээг цомхотогож, хэмнэлтээс нь төрд ажиллагсдын чадвар, үр өгөөжийг нэмэгдүүлэх түүнд нь ч дүйцэх нөхөн төлбөрийг олгох зайлшгүй шаардлагатай байдаг[8].

Зурагт 2-т инфляциараа тэргүүлж байсан улсууд ч эдгээр бодлогуудыг хэрэгжүүлж байна. Үр дүн нь жишээ нь Бразилд 1999- 2006 онд дундаж инфляци жилийн 8% болж чадсан нь гайхамшигтай амжилт юм. Чили, Мексикт өнөөдөр инфляци мөн л буурч Төв Банкууд нь инфляцийг жилд 2-4% д хувьд барих зорилго тавин ажиллаж байна.

Харамсалтай нь дотооддоо хөлөө олохгүй будилж байтал маань дэлхий нийтийг хамарсан хямд хүнсний эрин гэгдэж байсан үе дуусгавар болж нефть, газрын тосны үнэ урьд үзэгдээгүйгээр нэмэгдэх боллоо. Эдгээр нийлүүлэлтийн шокууд инфляцид хүчтэй нөлөөлдөг бөгөөд биднээс улам л ухаалаг сайн эдийн засгийн бодлого шаардаж байна.

[7] Mishkin (2000) and Fraga, Goldfajn, and Minella (2003). нараас хөгжиж байгаа улсуудад энэхүү бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх байгаа үүнтэй уялдуулж бусад ямар бодлого хэрэгжүүлвэл үр дүнтэйг уншиж болно.
[8] Санхүүгийн сахилга батыг сайжруулахгүйгээр, өөрөөр хэлбэл төсвийн зардлаа багасгахгүйгээр, зөвхөн мөнгөний нийлүүлэлтийн хурдыг багасгах нь инфляцийг бууруулдаггүй (Sargent and Wallace, 1981).

Ашигласан ном, материал:

Auty R. M. (2001). Resource Abundance and Economic Development, Oxford: Oxford University Press.

Barro, R.J. 2008. Macroeconomics: A Modern Approach. Thomson South-Western

Dornbusch, Rudiger, and Sebastian Edwards (1991). "The Macroeconomics of Populism," in R. Dornbusch and S. Edwards, eds., *The Macroeconomics of Populism in Latin America*. Chicago: University of Chicago Press.

Friedman, M. 1968. "*Inflation: Causes and Consequences*" in Dollars and Deficits. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall

Fisher, S., Sahay, R., and Vegh, C. 2002. "Modern Hyper- and High Inflations", *Journal of Economc Literature* 40, 837-80,

Fraga, Arminio, Ilan Goldfajn, and André Minella (2003). "Inflation Targeting in Emerging Market Economies," in M. Gertler and K. Rogoff, eds., *NBER Macroeconomics Annual*, pp. 365-400.

Khan, Mohsin, and Abdelhak Senhadji (2001). "Threshold Effects in the Relationship Between Inflation and Growth," *IMF Staff Papers*, vol. 48, pp. 1-21,

Mishkin, Frederic (2000). "Inflation Targeting in Emerging-Market Countries," *American Economic Review*, 90 (May), 105-09,

Sargent, T.J., and Wallace, N. 1981. "Some Unpleasant Monetarist Arithmetic" *Federal Reserve Bank of Minneapolis, Qauterly Review* (Fall), 1-17,

Solow, R. 1979. "What We Know and What We Don't Know About Inflation" *Technology Review* 81(3),